182

Б Н М А У

# УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 10 сарын 18 №351 Улаанбаатар хот

Компани байгуулах тухай.

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн Улаанбаатар хотын АХГЗ-аас ТОГТООХ НЬ:

нэг. Засгийн газрын дэргэдах Барилга,хот байгуулалтын комиссын даргын 1990 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 05 тоот тушаалаар байгуулагдаж тус захиргааны харьяанд шилжсэн Шинжлэх ухаан- үйлдвэрлэлийн " Бармаш " пүүсийг татан буулгаж " Бармаш компани " / ҮҮГ/ болгон өөрчлөн зохион байгуулсугай.

Хоёр. " Бармаш " компанийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

УБ ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ц.Болдсайхан.

183

Улаанбаатар хотын АХГ.Захиргааны
1991 оны 12-р сарын 18 ны өдрийн
351 тоот тогтоолын хавсралт

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА

## ШИНЖЛЭХ УХААН-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН "БАРИЛГЫН МАШИН" /БАРМАШ/ ЕРӨНХИЙ КОМПАНИЙН ДҮРЭМ.

### Нэг.Ерөнхий зүйл.

1.1.БНМАУ-ын Аж Ахуйн Нэгжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн энэхүү дүрмийг үйлдэв.Энэхүү дүрэм нь тус үйлдвэрийн үндсэн хөрөнгийг хувьд шилжүүлэх асуудлыг бүрэн шийдвэрлэгдэх хүртлэх хугацаанд хүчинтэй байна.

1.2.Ш.У.Ү-ийн "БАРМАШ" пүүсийг энэ өдрөөс эхлэн Шинжлэх Ухаан Үйлдвэрлэлийн "БАРМАШ" Ерөнхий Компани гэж нэрлэнэ.

1.3.Шинжлэх Ухаан Үйлдвэрлэлийн "БАРМАШ" Ерөнхий Компани /пааншид,компани/ нь энэхүү төрийн өмчийг бүхэлд нь эзэмшиж,үйл ажиллагаатайгаа холбогдсон эрхийг БНМАУ-ын хуулийн дагуу эдэлж, үүрэг гүйцэтгэж,хариуцлага хүлээж байх бие даасан тайлан тэнцэлтэй хуулийн этгээд мөн.

1.4.Ерөнхий компани нь улсын даалгавар,аж ахуйн гэрээг болон байгууллагын захиалгаар машины засвар-ашиглалтын болон барилгын үйлдвэрлэлийн тоног техеөремж,багаж,сэлбэг хэрэгслийг зохион бүтээж олноор нь үйлдвэрлэж,тэдгээрийг ашиглах,засварлахад хэрэглэх,техник технологийн горим,заавар,норм нормативыг боловсруулан нийлүүлэх мөн өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх ба бусад ажил үйлчилгээг гүйцэтгэж байх үүргийг улсын өмнө хүлээж БНМАУ-ын хуулиуд,энэ дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа бүрэн бие даан явуулна.

I.5.Компанийн үйл ажиллагаа нь орчин үеийн машины үйлдвэрлэл - дэх шинжлэх ухаан, техникийн ололтонд тулгуурлан, эх орныхоо нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах үндсэн цээр зохион бүтээж, үйлдвэрлэн гаргах, машин, тоног техээрөмж, багаж хэрэгсэл, салбэгийн зүйл болон бусад ажил, үйлчилгээгээр өөрийн орны эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдэнэ.

I.6.Еренхий компанийг татан буулгаж, аж ахуйн өөр нэгж болгох асуудлаар хамт олны саналыг харгалзан үзэж холбогдох дээд байгууллагууд шийдвэрлэнэ.

Харин компанийн дотоод нэгжүүдийн зохион байгуулалт, түүний эрхэлсэн ажил үйлчилгээ ба бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлийг өөрчлөх асуудлыг еренхий компанийн захиргаа шийдвэрлэнэ.

I.7.Еренхий Компани нь өөрийн ялгах тэмдэг тусгайлсан нэртэй байх ба тушаал, албан, бичгийн хуудас, тэмдгийг хэрэглэнэ.

I.8.Еренхий компанийн албан ёсны хаяг:

БНМАУ.Улаанбаатар хот.36А.

Ленинийн өргөн чөлөө

"БАРМАШ" Еренхий Компани.

Хоёр.<u>Еренхий компанийн удирдлага.</u>

2.I.Компани нь бүхэлдээ удирдлагын ардчилсан зарчим, хөдөлмөрийн хамт олон, салбар нэгжүүд тус бүрийн аж ахуйн төсөөг эрхэмлэнэ.

Еренхий компанийн эрх барих дээд байгууллага нь үйлдвэрийн захиргаа, салбар нэгжүүдийн хамт олон тус бүр түрээсийн хэсгийнхээ ахлагчаар сонгож, еренхий захирлын тушаалаар батлагдсан хүмүүсээс бүрдсэн ахлагч нарын зөвлөлийн хурал мөн. Ахлагч нарын зөвлөлийн чөлөө цагт еренхий захирал үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг удирдан явуулна.

2.2.Еренхий компанийн үйл ажиллагааг Улаанбаатар хотын АХГ. Захиргаанаас томилсон,иргэний гэрээ бүхий еренхий захирал удирдана.Еренхий захиралын ажиллах хугацаа дуусах буюу хүндэтгэх шалтгаанаар еерчлен томилох шаардлага гарвал,гэрээнд заасан үндэслэлийг харгалзан шийдвэрлэнэ.

2.3.Ажиллагчдын хеделгеенийг БНМАУ-ын хедelмерийн хуулийн дагуу хедэлмерийн гэрээгээр тухайн хамт олны саналыг харгалзан еренхий захирал шийдвэрлэнэ.

Гурав.<u>Еренхий Компанийн эрх.</u>

Компани дараах эрхийг эдлэнэ;ҮҮПП:

3.1.Салбар нэгжийн бүтэц бүрэлдэхүүнийг еерее тогтоох;

3.2.Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн,боловсруулсан зураг тесел, норм норматив,судалгаа-шинжилгээний хэрэглэгдэхүүн нь нүүсийн емч бегеед бусад байгууллага хүмүүст хэрэглүүлэхийг еерее шийдвэрлэх.

3.3.Стандартын бүтээгдэхүүн борлуулахад улсын нэгдсэн үнийг хэрэглэхийн зэрэгцээ,захиалагчийн хүсэлтээр хийж гүйцэтгэж байгаа стандартын бус бүтээгдэхүүн,ажил үйлчилгээ,мен түүнчлэн чанарын цэнд үнэлэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулахад тохиролцооны үнийг хэрэглэнэ.

3.4.Өерийн үйл ажиллагааг явуулахад хэрэглэх түүхий эд, материал,бараа,тоног техеерөмжийг еерее олж авах;

3.5.Бүтээгдэхүүнийг гадаадын үйлдвэрлэгчтэй хамтран үйлдвэрлэх,хамтын ажил,үйлчилгээ явуулах гэрээ,хэлэлцээрийг БНМАУ-ын гадаад хөрөнгө оруулалтын тухай болон бусад хуулийг мердлег болгон байгуулж,санхүүгийн тооцоог болон үндэсний валютаар хийх;

3.6.Ажиллагчдад эд хөрөнгийн ба мөнгөн тусламж,хөнгөлөлт үзүүлэх мөн түүний хэмжээг тогтоох;

3.7.Орлого хуваарилах зарчмыг баримтлан үйлдвэрлэл шинжлэх ухаан,техник,нийгмийг хөгжүүлэх,цалин ба шагналын сангийн хэмжээг өөрсдөө тогтоож,зарцуулах;

3.8.Бүх ажиллагчид хөдөлмөрөө хоршиж ба хүн бүрийн оруулсан хувь нэмэр,гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ,борлуулсан бүтээгдэхүүний тоо,чанарт тохируулан цалин хөлсийг тогтоох;

3.9.Техникийн зураг төсөл,норм норматив боловсруулах,сорилт туршилт явуулах хугацааг дотоод ба гадаадын ижил төстэй газруудын нормыг баримжаалан өөрсдөө буюу гэрээний үндсэн дээр тогтоох;

3.I0.Өөрийн үндсэн үйлдвэрлэлээс гадна ашиг орлого нэмэгдүүлэх,туслах үйлдвэрлэл ба үйлчилгээний салбар нэгжүүдийг ажиллуулах;

Дөрөв.Ерөнхий компанийн үүрэг.

Компани дараах үүргийг хүлээнэ.

4.I.Бүтээгдэхүүн,ажил үйлчилгээ,техникийн зураг төсөл,норм норматив болон сорилт туршилтын ажлыг мэргэжлийн өндөр түвшинд аж ахуйн гэрээгээр хүлээсэн хугацаанд гүйцэтгэх;

4.2.Ажиллагсдын мэргэшил,мэдлэгийг байнга дээшлүүлэх,өөрийн зардлаар мэргэжилтэн бэлтгэх,мэргэжилтнийг шилж сонгох,боловсрол олгох;

4.3.Ажиллагсадын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах,нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

4.4.Өөрийн ажиллагсадад тодорхой даалгавар ажлыг гэрээр гүйцэтгүүлэх,судалгаа туршилт,бүтээлийн чөлөө олгох зэргээр хөнгөвчлөх бүх талын боломжоор хангах ба шаардагдах мэргэжлийн хүмүүсийг түр хугацаагаар гэрээгээр ажиллуулж туслуулах;

зэрэг хэлбэрийг өргөн хэрэглэх;

4.5.Үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж,засварласан агрегат,машины ашиглалтанд гэрээний дагуу зохиогч,гүйцэтгэгчийн хяналт тавих.

4.6.Борлуулсан бүтээгдэхүүн гүйцэтгэсэн ажил үйлчилгээний чанарт гологдол илэрвэл түүнийг үнэ төлбөргүй засаж залруулж өгөх ба учирсан хохирлыг хариуцах;

4.7.Машин төхөөрөмж,зураг төсөл/багаж хэрэгслийн/,норм норматив боловсруулах,судалгаа туршилтын ажил гүйцэтгэхэд техникийн мэдээлэл болон багаж хэрэгслээр хангах;

4.8.Улсад албан татварыг хугацаанд нь хожимдуулахгүй төлөх;

Тав.Санхүү,аж ахуйн үйл ажиллагаа.

5.1.Санхүү,бүртгэлийн ажлын тогтолцоо нь БНМАУ-ын холбогдох хуулийн дагуу явагдана.

5.2.Санхүүгийн ажил нь тухайн оны 01-р сарын 01-нээс эхэлж 12-р сарын 31-нд дуусна.Эмч хувьчлагдах тохиолдолд энэ хугацаа үйлчлэхгүй;

5.3.Тайлан тэнцэл бүртгэл тооцоог хууль тогтоомжийн дагуу хөтөлж,улирал хагас жил,жилийн эцсээр хамт олны хурал буюу хэсгийн ахлагч нарын зөвлөлөөр хэлэлцүүлж,дараагийн үе шатны ажлын чиглэл гаргаж байна.

5.4.Салбар нэгжүүд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмыг баримтлан дотоод тооцоотой ажиллана;

5.5.Салбар нэгжүүдэд Ерөнхий компанийн хэтийн чиг бодлогыг баримталсан техник технологийн түвшинг дээшлүүлэх,үйлдвэрлэлээ өргөтгөн шинэтгэх болон нийгмийн зарим асуудлыг шийдвэрлэхэд нь банкнаас урт хугацааны зээл авч хэрэгжүүлнэ.

5.6.Ерөнхий компани хөрөнгө оруулалт технологийн шинэчлэлийн банканд харилцах данстай байна,салбар нэгжүүдийг аж ахуйн дотоод тооцооны данстай болгох асуудлыг шийдвэрлэнэ.

5.7.Шаардагдах байр,тоног төхөөрөм,багаж,хэрэгсэл,материал түүхий эд,хөрөнгийг бусад байгууллага,хүмүүсээс худалдан авах, түрээслэх,мөн өөрийн хэрэгцээнээс илүүдсэн дээрх зүйлсийг өмч хувьчлалын комиссын зөвшөөрлөөр бусдад худалдах ба түрээсээр өөрөө шийдвэрлэж өгнө.

Зургаа. Дотоод журам.

6.1.Компанийн дотоод журмыг БНМАУ-ын хөдөлмөрийн хуулийн дагуу боловсруулан гаргах бөгөөд үүнд дараах зүйл багтана.Үүнд:

а. салбар нэгжүүд хоорондын үйл ажиллагаа тэдгээрийн ажлын журам;

б. ажилтан,ажилчидтай холбогдсон /тэдгээрийн эрх,үүрэг г.м./ журам;

в. галын

г. урамшуулалт,шийтгэл;

д. нийгэм хангамжийн асуудал;

е. санхүү,тооцооны тогтолцоо;

ё. бусад журам,дүрэм;

Долоо.Эцсийн тооцоо хийх,компанийг татан буулгах.

7.1.Үйл ажиллагааг зогсоох тухай шүүхийн шийдвэр гарснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа зогсвол ерөнхий компанийн эцсийн тооцоог удирдлага хийнэ;

7.2.Эцсийн тооцоо хийх тухай банкинд мэдэгдэж дуусгалын тэнцэл гаргаж хянуулан,ерөнхий компанийг улсын бүртгэлээс хасуулна.

7.3.Ерөнхий компанийг улсын бүртгэлээс хасуулснаар түүнийг татан буулгасанд тооцно;